



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаах хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 335,526,700.00 (гурван зуун гучин таван сая таван зуун хорин зургаан мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ, 302,855,530.72 (гурван зуун хоёр сая найман зуун тавин таван мянга таван зуун гучин төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Онцгой байдлын ерөнхий газрын холбогдох орон нутгийн Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2 Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, тогтоолд заасан салбар, нэгжийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000439

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашинныг төв болгон
орон нутгийн салбар нэгжүүдэд балансаас балансад шилжүүлэх жагсаалт



Д/д	Үндсэн хөрөнгө шилжүүлж буй салбарын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Үндсэн хөрөнгө хүлээн авч салбарын нэр
1	ОБЕГ-ын Үндэсний аврах бригад	Ланд, круизер-200, суудлын 00-73 УНЗ, арал	2008	ш	1	95,306,000.00	95,306,000.00	95,306,000.00	-	Булган аймгийн Онцгой байдлын газар
2	ОБЕГ-ын Үндэсний аврах бригад	Ниссан патрол, суудлын 29-24 УБН	2013	ш	1	55,220,700.00	55,220,700.00	50,618,975.22	4,601,724.78	Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар
3	Орхон аймгийн Онцгой байдлын газар	Зил-130 АЦ-40, 00-81 ОРО	2009.05.01	ш	1	142,000,000.00	142,000,000.00	142,000,000.00	-	Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар
4	Хэнтий аймгийн Онцгой байдлын газар	Түймэр унтраах зориулалттай БМГ-1	2015	ш	1	43,000,000.00	43,000,000.00	14,930,555.50	28,069,444.50	Үндэсний аврах бригад
Нийт дүн						335,526,700.00 (Гурван зуун гучин таван сая таван зуун хорин зургаан мянга долоон зуун төгрөг)	335,526,700.00 (Гурван зуун гучин таван сая таван зуун хорин зургаан мянга долоон зуун төгрөг)	302,855,530.72 (Гурван зуун хоёр сая найман зуун тавин таван зуун гучин төгрөг далан хоёр мөнгө)	32,671,169.28 (Гучин хоёр сая зургаан зуун далан нэгтэн мянга нэг зуун жаран есөн төгрөг хорин найман мөнгө)	